

ХАККАЧУУДЫН ТУХАЙ

Д. ТҮВШИН*

БНХАУ-ын нийт хүн амын 90 гаруй хувь нь хань буюу хятад үндэстэн болохыг бид мэдэх билээ. Тэгвэл дэлхий дээр хамгийн өнөр үндэстэн хятадууд нь оршин суугаа нутаг нутгаараа хэл аялгуу, зан заншлын хувьд нэлээд ялгардаг юм. Хэдийгээр хятадуудын дийлэнх олон нь мандарин аялгуугаар ярих боловч /mandарин аялгуу дотроо бас олон аялгатай/ Хятадын өмнө зүгийн Чжэцзянь, Фуцзянь, Гуандун зэрэг мужид умард нутгийнхан үл ойлгох аялгуугаар ярина. Ер нь зан заншлын хувьд ч Хятадын умард болон өмнөд нутгийнхан тодорхой ялгаатай юм. Олон зууны туршид Хятадын нутгууд дотор шилжилт хөдөлгөөн явагдаж умард, өмнөдийн соёл харилцан нэвтрэлцэж ирсэн ч ялгаа одоо хүртэл хэвээр байгаа юм. Тухайлбал Евэн сар, Луут завины наадам зэрэг баярыг БНХАУ-д үндэсний баяр болгон бүх нийтээр тэмдэглэдэг боловч Евэн сар нь умард Хятадын баяр бөгөөд тэнд илүү сүр жавхлантай тэмдэглэдэг байна. Эрт дээр үеэс Өмнөд Хятадад гол мөрөн дээр луун хэлбэрт завиар уралддаг байсан баяр өнөө үед мөн л Өмнөд Хятадад хамгийн хөөр хөгжөөнтэй тэмдэглэдэг. Хоол хүнсний хувьд, будаа болон гурил /гоймон/ хятадуудын хүнсний гол хэрэглэгдэхүүн бөгөөд өмнөд Хятадад будааг, Хойд Хятадад гоймон, мантуу, бууз, бин зэрэг гурилан бүтээгдэхүүн голлон хэрэглэнэ.

Харин энд монголчууд бидний тэр бүр мэдэхгүй өмнөд Хятадын хаккачуудын тухай товч танилцуулах гэсэн юм. Дэлхий дээрх нэг тэрбум 300 сая хятадуудын дөрөв орчим хувь өөрсдийгөө хакка буюу хакка гаралтай гэж тооцдог байна. Хаккачууд ихэвчлэн өмнөд Хятадын Гуандун мужийн зүүн хойд хэсгийн Мэйсянь тойрогт голлон, мөн Фуцзянь мужийн баруун өмнөд хэсэг, Хайнань арал, Гуанси мужийн зарим хэсэгт амьдардаг бөгөөд гуандун аялгуунаас ихээхэн ялгаатай хакка аялгуугаар ярьдаг. Хятадын түүхэн дэх хамгийн аянчин, далайчин хүмүүст тооцогддог тэд XIX зууны үеэс эхлэн Вьетнам, Тайланд, Малайз, Индонез руу ихээр цагаачилсан ба Хар тамхины дайн, Тайпингийн бослого зэргээс болж 1867 оноос Тайвань, Хайнань арал, Гуанси муж руу олноор нүүдэллэн суурьшсан байна. Ийнхүү тэд Хятадын цагаачлалын түүхийг гуандун, миннань /Фуцзянь мужийн өмнөд хэсгийн/

* Д.Түвшин - ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

хүмүүсийн хамтаар эхлүүлсэн юм. Одоо ч хаккачууд АНУ, Австрали, Канад, Европ, Өмнөд Африк, Латин Америк, бүр Энэтхэгийн далай дахь Маврики арал хүртэл дэлхийн ихэнх улс оронд цагаачлан аж төрж байна. Зүүн өмнөд Ази дахь хятад цагаачдын гуравны нэг орчмыг хаккачууд эзэлнэ. Хаккачууд дэлхийн хаана ч цагаачлан очсон тухайн оронд маш хурдан дасан зохицож, бизнес эрхлэн хятад хоолны газар, дэлгүүр байгуулан, аажмаар хятад хороолол, хятад иргэдийн нийгэмлэг байгуулан бусад хятадуудад цагаачлан очих зам тавьж өгдөг байна. Антарктидад нэгэн хятад зоогийн газар байсан нь хакка эзэнтэй байлаа гэсэн шог яриа ч үүнтэй холбоотой байх аа.

Хаккачууд нь Хятадын түүхэнд өөрийн гэсэн ул мөртэй юм. Аянчин, далайчин хаккачууд анхнаасаа л өмнөд Хятадын Гуандун мужид амьдарч байв уу гэвэл үгүй юм. Түүх сөхвөл, XVI зууны үед төв Хятадын Хэнань мужийн өмнөд хэсгийн Шаолин хийд орчмын нутгаас асар олон тооны хүн тухайн үед гарсан бослого хөдөлгөөн, үймээн самуунаас дайжин, урагш нүүдэллэн Хунань мужаар дамжин Гуандунд хүрч суурьшсан нь өнөөгийн хаккачуудын өвөг дээдэс юм. Хакка гэдэг нь мандаринаар кэцзя буюу зочин хүн гэсэн утгатай үг бөгөөд гуандунчууд тэднийг ийнхүү нэрийджээ. Харин хаккачууд өөрсдийгөө хаагта гэдэг байна.

Харин гадаадын /Японы болон АНУ-ын/ зарим түүхчдийн үздэгээр хаккачуудын өвөг дээдэс бүр эртний хүннүчүүдтэй холбогдох юм. Хүннү улс мөхөхдөө Хойд Хүннү, Өмнөд Хүннү болон хоёр хуваагдан тэмцэлдэн, Хойд Хүннү ялснаар өмнөд хүннүчүүд Шар мөрнийг гэтлэн Хятадын дотор газар Шаньси муж, хожим Хэнань мужийн өмнөд хэсэгт суурьшжээ. Аажмаар олон зууны туршид тэд хятадуудтай холилдон уусчээ.

АНУ-ын хакка түүхч Клайд Жянь /Clyde Kiang/-ы бичсэн "The Hakka Odyssey" номд өгүүлсэнээр МЭ 280 оны үед Хятад орон 2,45 сая хүн амтай байсан ба энэ үед өмнөд хүннүгийн 200 гаруй мянган хүн Шаньси, Шэньси мужууд руу нүүдэллэн орж иржээ. Түүнчлэн Японы эрдэмтэн Хидео Мацумото 1966 онд хятадын янз бүрийн нутгийн хүмүүс болон Япон, Солонгос, зүүн өмнөд азийн олон орны хүмүүсийн цусанд хийсэн шинжилгээгээр хаккачуудын генийн ДНК нь Хятадын бусад нутгийнхан болон зүүн өмнөд азийн үндэстнүүдийнхээс эрс өөр, харин япон, солонгосчуудынхтай төстэй гарчээ. Үүнээс үндэслэн Японы зарим эрдэмтэд хаккачуудыг хятад бус, хүннү гаралтай хэмээн үзэхэд хүргэжээ. Өнөө үед энгийн олон япон хүн хаккачуудыг хараад япончуудтай ямар адилхан юм бэ гэж дуу алддаг аж. Үнэхээр ч

хаккачууд царай зус, антропологийн хувьд бусад хятадуудаас нэн ялангуяа, зүүн өмнөд азийнхнаас эрс ялгаатай, японжуу буюу монголжуу царайтай байна. Харин хаккачуудын япончуудтай холбоотой болохыг зарим эрдэмтэд өөрөөр тайлбарладаг юм. Эртний Цинь улсын үед Циньшихуанди хаан түшмэл Сю Фу-г 3000 охид, хөвгүүдийн /Шаньси мужийн/ хамт Япон руу мөнхийн ус авчруулахаар явуулсан нь тэндээ үлджээ. Сю Фу болон тэдгээр охид, хөвгүүд Японы Кюсю аралд хүрсэн ба Кюсю арал дахь одоогийн Фукуока хотын дэргэдэх нэгэн ууланд Сю Фу түшмэлийн шарил байдаг ба Фукуока хотын нэр нь Фугийн уул гэсэн утгатай аж. Мөн одоогийн Ямато овог нь Сю Фу түшмэлтэй хамт ирсэн хөвгүүдээс гаралтай гэж үздэг байна.

Хаккачуудын өвөг дээдэс Хэнаниас Гуандун руу нүүдэллэн сурышсанаар хойд хятадын соёлыг өмнөдөл нэвтрүүлж, хятад үндэстний нэгдэл, нягтралд тодорхой хувь нэмэр оруулсан байна.

Түүхэнд хаккагийн нийгэмд эмэгтэйчүүдийн эзлэх байр суурь ямагт өндөр байснаараа бусад хятадуудаас ихээхэн ялгаатай. Гэр бүл, овгийн хүрээнд эмэг эх болон эхчүүд, ер нь хамгийн ахмад настай эмэгтэйчүүд олон асуудлыг шийдвэрлэх эрхтэй байжээ. Манж Чин улсын хатуу бодлогын үед ч хаккачууд охид, эмэгтэйчүүдийнхээ хөлийг боодоггүй байжээ.

Өнөө үед хаккачуудыг нэг талаар маш их хуучинсаг буюу хятадын эртний өв, уламжлал соёлыг хамгийн их хадгалж үлдсэн, бас нөгөө талаар хамгийн орчин үежсэн, шинэ дэвшлийг хүлээж авахдаа бусад хятадуудаас түргэн гэж үздэг байна.

Хаккачууд өнөө үед эх газрын Хятадын хүн амын багахан хувийг эзлэхээс гадна, Тайваний хүн амын 15 орчим %, Сингапурын хүн амын 20 орчим хувийг эзлэдэг бөгөөд тэдний дундаас нэр цуутай хүмүүс олон төрж гарсан. Тухайлбал, Хятадын шинэчлэлийн эцэг гэгдэх Дэн Сяопин /тэр хэдийгээр Сычуань мужид төрсөн боловч уг гарал нь хакка хүн юм/, Тайваний ерөнхийлөгч асан Ли Дэнхуэй, Сингапурын ерөнхийлөгч асан Ли Куанью нарыг дурдаж болно. Одоогоос 150-иад жилийн өмнө өлсгөлөн, ядуурлаас болж нутгаа орхин одсон уранхай хувцас, дэрсэн шаахайтай хакка цагаачид хүн тэрэгчин, гудамжны гутал тослогч байсан бол өнөөдөр Индонез, Малайз, Сингапурт банк санхүүгийн ихэнхийг атгасан хамгийн баян үйлдвэр, худалдааны эзэд болжгоожээ.